

ҮНЭТ ЦААСНЫ ГАЗРЫН 2009 ОНЫ ЖИЛИЙН АЖЛЫН ТАЙЛАН

2009 оны эцсийн байдлаар Хөрөнгийн зах зээл дээр арилжаа эрхлэх байгууллага 1, үнэт цаасны төлбөр тооцоо, хадгаламжийн байгууллага 1, брокер, дилерийн 48 компани, нийтэд үнэт цаасаа санал болгон гаргасан 368 ХК үйл ажиллагаа явуулж байна.

Эдгээр 368 ХК-ийн 23 нь 100 хувь төрийн өмчит ХК, 28 нь төрийн өмчийн оролцоотой ХК байгаа бөгөөд үлдсэн бүрэн хувьчлагдсан 317 ХК-ийн нилээд хэсэг нь үнэн хэрэгтээ дампуурч, ямар ч хөрөнгөгүй болсон, бараг тал нь дөнгөж зардлаа нөхөх төдий хэмжээнд үйл ажиллагаа явуулдаг, идэвхтэй арилжигддаг үнэт цаасны тоо цөөн байгаа нь зах зээлийн хөрвөх чадварт муугаар нөлөөлсөөр байгаа төдийгүй хөрөнгө оруулагчдын эрх ашигт ноцтой хохирол учруулсаар байна.

Нийт компанийн хувьцааны ихэнх нь нэгдмэл сонирхол бүхий цөөн хэдэн хүний гарт төвлөрснөөс хувь нийлүүлэгчдийнхээ жил бүрийн ээлжит хурлыг хийх, санхүүгийн тайлангаа Хороонд ирүүлэх, олон нийтэд хүртээл болгох, ногдол ашиг хувиарлах зэрэг хуулиар хүлээсэн үүргээ бүрэн биелүүлдэггүй, жижиг хувьцаа эзэмшигчдийн хувьцааг үнэгүйдүүлэх зэргээр эрх ашгийг нь хохироох, компанийн хөрөнгийг хууль бусаар захиран зарцуулах зэрэг үйлдлүүд гарсаар байна.

Нөгөө талаар үнэт цаас гаргасан компани хувьцаа эзэмшигчдийнхээ өмнө хуулиар хүлээсэн үүрэг, хариуцлага болон үнэт цаасаар гэрчлэгдсэн эрхийн талаар бүрхэг ойлголттой олон тооны жижиг хувьцаа эзэмшигчдийн зүгээс компанийн үйл ажиллагаанд тавих хяналт сул байгаа нь компанийн удирдлага хуулиар хүлээсэн үүргээ биелүүлэхгүй байх нэг шалтгаан болж байна.

Жижиг хувьцаа эзэмшигчдийн зүгээс өмчлөх эрхээ хэрэгжүүлэх идэвх ч туйлын хангалтгүй байгаа юм. Үүний нэг жишээ нь ХОЭБ-ээр нийт нээгдэх ёстой 843192 данснаас 86.3 хувь буюу 727.565 данс нээгдэж, 13.7 хувь буюу 115.627 данс нээгдээгүй байгаа явдал юм.

Үнэт цаасны төлбөр тооцоо, хадгаламжийн үйл ажиллагааг эрхэлдэг төрийн өмчит “Үнэт цаасны төлбөр тооцоо, төвлөрсөн хадгаламжийн төв” /ҮЦТТТХТ/ ХХК-д 2009.12.14-ний байдлаар нийт 559.394 хувьцаа эзэмшигчдийн данс байгаа бөгөөд Үүнээс:

- дансаа нээлгэсэн 443.767 хувьцаа эзэмшигч
- дансаа нээлгээгүй 115.627 хувьцаа эзмшигч байна.

Хувьцаа эзэмшигчдийн бүтцийг дараах хүснэгтээр үзүүллээ.

"ҮЦТТТХТ" ХХК-ийн дансны
судалгаа

09.12.14

Нээгдсэн				Нээгдээгүй		Нийт
443767		79.33 хувь		115627	20.67 хувь	559394
Иргэн		ААНэгж				
Монгол	Гадаад	Монгол	Гадаад			
442423	623	654	67			

Иргэдийг үнэт цаасны арилжаанд оролцоход зуучлах үүрэг бүхий брокер, дилерийн зарим компани хувьцаа эзэмшигч нарын хувьцааг зөвшөөрөлгүйгээр худалдах, үнэт цаасны ханшид зохиомлоор нөлөөлөх, дотоод мэдээллийг ашиглан арилжаанд оролцох зэрэг

зохисгүй үйлдлүүд өмнөх онуудтай харьцуулбал багасч байгаа бөгөөд шинээр гарсан тохиолдол байхгүй байгаа бөгөөд олон жилийн өмнөх үйлдлүүдийн мөрөөр ирсэн иргэдийн өргөдөлд гомдлыг барагдуулах ажлыг хийж байна.

2009 онд харилцагчийнхаа хөрөнгийг зөвшөөрөлгүй зарсан гэсэн үндэслэлээр Хороонд хандаж, 325 гаруй иргэдээс өргөдөл гомдол ирсэн бөгөөд эдгээрийн дийлэнхийг тусгай зөвшөөрөл нь цуцлагдсан “Ажнай”, “Мөнхөд” БДК-ийн харилцагчдын өргөдөл эзэлж байна. Эдгээр компанийн ажилтнууд гол төлөв 1998-2004 оны үед иргэдийн хувьцааг зөвшөөрөлгүй зарсан байгаа бөгөөд хохирсон гэж өргөдөл гаргаад байгаа иргэдийн тоо 400 орчим, хохирлын хэмжээ өнөөгийн зах зээлийн үнээр тооцоход бараг 1,5 тэрбум болоод байна. Эдгээр компанийн эрх бүхий албан тушаалтантай холбогдох эрүүгийн хэргийг шалгахад шаардагдах Хороонд олдож болох үндсэн баримтыг тухай бүр гарган цагдаагийн газарт хүргүүлж байсан болно.

Энэ байдалд дүгнэлт хийж 2009 он гарсаар харилцагчдын өмчлөлийн үнэт цаас, мөнгөн хөрөнгийн хадгалалт, хамгаалалт, эзэмшигчдийн нь зөвшөөрөлгүй гүйлгээнд оруулахгүй байх талаар бүх өмчлөгч эзний нь гарын үсгийн баталгааг гаргуулан төлбөр тооцооны байгууллага дээр мэдээллийн сан үүсгэн хадгалах ажлыг эхлүүлэн хийж байна.

2009 онд Хорооны Үнэт цаасны газар дээрх хууль бус үйлдлүүдийг таслан зогсоох, эдгээр асуудлуудыг шийдвэрлэх арга замуудыг тодорхойлох, мөрдөгдөж буй холбогдох салбарын хуулиудад нэмэлт өөрчлөлт оруулан боловсронгуй болгох, эрх зүйн хувьд зохицуулахад шаардагдах дүрэм, журмуудыг нэн тэргүүнд боловсруулан баталж мөрдүүлэх, хуулийн хэрэгжилтийг хангах, үнэт цаас гаргах үйл ажиллагааг идэвхжүүлэх, хувьцаа эзэмшигчдийн эрх ашгийг хамгаалах, үнэт цаасны зах зээлд оролцогчдын санхүүгийн боловсролыг дээшлүүлэх, зах зээлд оролцогчдын үйл ажиллагаанд тавих хяналтыг сайжруулахыг зорилго болгон ажиллаж байна.

Мөн түүнчлэн хөрөнгийн зах зээлд анх удаа нийтэд хувьцаа гаргах /IPO/ асуудал, анхдагч зах зээлийн үнэ тогтох, хэдийд хоёрдогч зах зээл эхлэх зэрэг асуудлын зохицуулалт бүрхэг, үнэт цаасны зах зээлийн мэргэжлийн байгууллагуудын эрх үүрэг тодорхой биш, анддеррайтерийн компанийн үүрэг хариуцлага олон улсын нийтлэг жишгээс өөр, үнэт цаасны зах зээлийг зохицуулах байгууллагын үүрэг тодорхойгүй, эрх хэмжээ бага, хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн, тэр дундаа жижиг хувьцаа эзэмшигчдийн эрхийг хамгаалах цогц арга хэрэгсэл байхгүй, тэд эзэмшиж буй хувьцааны хэмжээгээр компанийн удирдлагад оролцох боломжоо бүрэн эдэлж чаддаггүй, мэдээлэл хаалттай, нээлттэй тайлагналын асуудлын зохицуулалт хангалтгүй, ногдол ашгийн хувиарлалт шударга биш, компанийн эрх бүхий албан тушаалтны хариуцлагыг өндөржүүлэх, жижиг хувьцаа эзэмшигчийн гомдол гаргах эрх хязгаарлагдмал байгаад дүгнэлт хийх ажиллаж байна.

Үнэт цаас гаргагч, мэргэжлийн оролцогч байгууллагуудын хувийн хэргүүдийг Архивын тухай хуулийн дагуу цэгцлэх ажлын хүрээнд 419 хадгаламжийн нэгж болгон эмхлэж байгууллагын архивт хүлээлгэн өглөө.

2009 онд Газраас хөрөнгийн зах зээлийг зохицуулах, цаашид хөгжүүлэх талаар дараах дараах ажлуудыг хийж гүйцэтгэлээ.

Хууль эрх зүйн орчинг боловсронгуй болгох талаар: Монгол улсад үнэт цаасны зах зээл үүсч хөгжсөнөөс хойшхи хугацаанд уг зах зээлийн талаар төрөөс баримтлах бодлого, хөтөлбөр, төлөвлөгөөгүйгээр явж ирсний улмаас энэ зах зээл үндсэндээ урсгалаараа явж ирсэн байдалд дүгнэлт хийж хөрөнгийн зах зээлийн эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох, зорилт тавин ажиллаж байна.

Манай хамт олон үнэт цаасны зах зээлийн салбарынхаа эрх зүйн зохицуулалтыг зах зээлийн хөгжлийн өнөөгийн шаардлагад нийцүүлэх асуудлыг чухалчилж, салбарын хуулиудад оруулах нэмэлт өөрчлөлт, зарим хуулийн шинэчилсэн найруулгын төсөл, зарим шинэ хуулийн төслийг тус тус боловсруулан холбогдох газруудад хүргүүлж байсан хэдий ч өнөөг хүртэл хараахан батлагдаж чадаагүй байсаар байгаа юм.

Манай улсын ихэнх бүртгэлтэй хувьцаат компаниудын хувьцааны хяналтын багцаас дээш хувийг цөөхөн тооны томоохон хувьцаа эзэмшигч нар эзэмшдэг бөгөөд тэдгээр нь компанийн үйл ажиллагааг удирдаж, хувьцаат компанийг хувийн ганц нэг хүний хөрөнгө мэтээр ашиглах, үнэгүйдүүлэх, ашиггүй мэт харагдуулах, ашиг орлогоос зөвхөн өөрсдөө хүртдэг зэргээр дураар авирлах үйлдэл ихээр гардаг бөгөөд энэ байдлыг зохицуулах зорилгоор 2009 онд үнэт цаасны зах зээлд дагаж мөрдөж байсан эрх зүйн актуудыг боловсронгуй болгох, хөгжиж буй зах зээлийн шаардлагад нийцүүлэх ажлын хүрээнд дараах ажлыг хийлээ.

* “Үнэт цаасны зах зээлийн тухай” хуулийн шинэчлэсэн найруулгыг Хууль зүй дотоод хэргийн яам, Сангийн яамнаас томилогдсон мэргэжилтнүүдтэй хамтран ажиллаж, уг хуулийн төслийг эцэслэн боловсруулан гаргаад байна.

* Хамтын хөрөнгө оруулалтын байгууллагын эрх зүйн статусыг тодорхой болгох, тэдгээрт тавих шаардлага, үйл ажиллагааны зарчмыг тодорхой болгох, гадаадын хөрөнгө оруулалтын байгууллага Монголд үйл ажиллагаа явуулах асуудлыг хуульчлах чиглэлээр “Хөрөнгө оруулалтын сангийн тухай” хуулийн төсөл боловсруулж, Сангийн яаманд хүргүүлээд байна.

* Компанийн эрх зүйн байдлыг тодорхой болгох замаар мэдээллийн тогтолцоо бүрдүүлэх, компанийн удирдлагын үүрэг хариуцлагыг тодорхой болгох, хөрөнгө оруулагчид, ялангуяа жижиг хувьцаа эзэмшигчдийн эрх ашгийг хамгаалах, ТУЗ-ийн үүрэг хариуцлагыг өндөрсгөх, бүтэц бүрэлдэхүүнд тавих шаардлагыг тодорхой болгох замаар сайн засаглалын практикийг хэвшүүлэх эрх зүйн орчныг бүрдүүлэх чиглэлээр “Компанийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хууль-ийн төсөл боловсруулан холбогдох байгууллагад хүргүүлсэн бөгөөд Засгийн газрын хуралдаанаас дэмжигдэж, Улсын их хуралд өргөн баригдсан.

* Үнэт цаасны тухай хууль тогтоомжтой холбоотойгоор Эрүүгийн хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулан холбогдох эрх бүхий байгууллагуудын саналыг тусган өргөн барихад бэлэн болгоод байна.

* Бөөний худалдааны биржийн тухай хуулийн төсөл боловсруулах ажлын хэсэгт Газрын ажилтнуудаас орж ажилласан ба Бараа ажил, үйлчилгээний үнэ, төлбөр тооцоог үндэсний мөнгөн тэмдэгтээр гүйцэтгэх тухай хуулийн төсөлд өөрийн газрын чиг үүргийн хүрээнд санал өгөв.

* “Барилга хот байгуулалт, нийтийн аж ахуйн үндэсний төв”-ийн хүсэлтийн дагуу Барилга, хот байгуулалт, нийтийн аж ахуйн үндэсний төвөөс гаргасан “Орон сууцны нийтийн аж ахуйн конторуудыг хувьчлах” журамд санал өгөв.

* Бэлэн ба бэлэн бус төлбөр тооцоонд хяналт тавих тухай хуулийн төсөлд тусгуулахаар санал боловсруулж өгөв.

* Зээлийн мэдээллийн тухай хуулийн төсөлд санал өгөв.

* Нийтэд санал болгон үнэт цаас гаргах ажиллагааны зохион байгуулалтыг үнэт цаас гаргагч, хөрөнгө оруулагчдын аль алины эрх ашигт нийцүүлэх, анхдагч зах зээлд үнэт цаас гаргах этгээдэд тавих шаардлага болон хөрөнгө оруулагчдад хүргэх мэдээлэл, танилцуулгын агуулыг тодорхой болгох, үнэт цаасыг анхдагч зах зээлд арилжих арга хэлбэрийн талаар зохицуулалт бий болгох, хөрөнгийн зах зээлд гарч буй шинэ хандлагыг зохицуулах чиглэлээр “Нийтэд санал болгон гаргах үнэт цаасыг бүртгэх тухай” журмын шинэчлэсэн найруулгыг Хорооны 2009 оны 2 дугаар сарын 19-ний өдрийн 38 дугаар тогтоолоор батлууллаа.

Өнгөрсөн 2009 онд жилийн хугацаанд мэргэжлийн байгууллага, үнэт цаас гаргагчдын үйл ажиллагаатай холбогдон үүссэн төрөл бүрийн харилцааг зохицуулахад чиглэсэн, нийтээр дагаж мөрдөх хэм хэмжээ тогтоосон 67 тогтоолын төслийн эхийг болон холбогдох үндэслэх баримт бичгийг хянаж бүрдүүлний үндсэн дээр дээрх хэмжээний Хорооны тогтоолыг гаргуулсан байна.

“Нийтэд санал болгон гаргах үнэт цаасыг бүртгэх тухай” журмыг цаг үеийн шаардлагад нийцүүлэн уг журмын шинэчилсэн найруулга, “Сэжигтэй болон бэлэн мөнгөний гүйлгээг мэдээлэх тухай” журмыг шинээр боловсруулан батлууллаа

Түүнчлэн үнэт цаас нь нийтэд чөлөөтэй арилжаалагддаг хувьцаат компаниудын удирдлага, зохион байгуулалтын тогтвортой бөгөөд зохистой ажиллагааны нөхцлийг бүрдүүлж, улмаар хувьцаа эзэмшигчид болон компани хоорондын итгэлцэл хэвээр хадгалагдаж, тухайн компанийн хөрөнгө оруулалт татах чадвар өсөн нэмэгдэх ач холбогдолтойг харгалзан “Компанийн засаглалын кодекс”-ийг 2007 онд зөвлөмж болгон баталсан ба Дэлхийн банкны 2009 оны “Монгол улс дахь компанийн засаглалын үнэлгээний тайлан”-гаар өгсөн зөвлөмжийн дагуу уг кодекс нэмэлт өөрчлөлтүүдийг Хорооны 2009 оны 11 дүгээр сарын 23-ны өдрийн хуралдаанаар хэлэлцэн баталсан.

Мөн Хорооны болон Үнэт цаасны хорооны эрх зүйн актуудын өмнөх жилд бүрдүүлсэн санг баяжуулж, эрх зүйн актад өөрчлөлт орох тухай бүр кодификаци хийж ирлээ. Хорооны байгуулагдсанаас хойшхи хугацаанд гаргасан Үнэт цаасны зах зээлтэй холбоотой бүх тогтоолын товъёогийг цахим хувиар хийж дуусгалаа. Нэмж гарах бүр тухай бүр нь баяжуулалтыг хийж байна.

Хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих ажлын хүрээнд: Компанийн тухай болон Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, холбогдох бусад журам, зааврыг Хөрөнгийн биржид бүртгэлтэй хувьцаат компаниуд, үнэт цаасны зах зээлд үйл ажиллагаа эрхэлдэг мэргэжлийн байгууллагууд хэрхэн мөрдөж хувьцаа эзэмшигчдийн өмнө хүлээсэн үүргээ биелүүлж байгаа байдалд болон санхүүгийн гэмт хэрэг, зөрчил гарах явдлаас урьдчилан сэргийлэх, гарсан зөрчил дутагдлыг арилгах үүднээс 2009 онд Орхон, Дархан-Уул, Ховд, Өвөрхангай, Сэлэнгэ аймгуудын 28 ХК-д газар дээрх үзлэгийг зохион байгуулж, IPO хийсэн 10 ХК-д, “МХБ” ХК, “ҮЦТТТХТ” ХХК, Брокер дилерийн 39 компанид тус тус шалгалт хийж гүйцэтгэсэн байна. *Зах зээлийн мэргэжлийн оролцогчдын үйл ажиллагаад хийсэн шалгалтын нэгдсэн тайланг хавсаргав.*

Орон нутагт буюу Хөвсгөл, Орхон аймгуудад Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн байгууллагын ажилтнуудыг ажлуулах ажлыг зохион байгуулж төвлөрсөн хадгаламжид байгаа хөрөнгийн үлдэгдлээ шалган баталгаажуулах, дансаа нээгээгүй иргэд данс нээх талаар нэгдсэн арга хэмжээ болгон зохион байгууллаа.

Энэ арга хэмжээний хүрээнд нийт 360 орчим иргэнд төвлөрсөн хадгаламж дах дансны талаарх үйлчилгээг үзүүлж, 41 иргэнд хувьцаа худалдсаны орлого, ногдол ашгийн мөнгө болох 2.950.434 төгрөгийн мөнгөн хөрөнгийг гарт нь олголоо.

Шалгалтанд хамрагдсан IPO хийсэн ХК-иудын жагсаалт

	Компанийн нэр	Хороонд бүртгүүлсэн огноо	Олон нийтээс татсан хөрөнгийн хэмжээ	Үзлэг хийх хугацаа	Үзлэг хийх мэргэжилтэн
1	“Монгол шилтгээн” ХК	2005.04.28	800,000,000	I/12-I/23	Ц.Орхонтамир Ш.Түмэнбаяр
2	“Женко тур бюро” ХК	2006.01.11	7,365,265,529	II/2-II/13	П.Наранцэцэг Т.Жамбаажамц Ж.Өнөрболд А.Хулан
3	“Бидисек” ХК	2006.06.23	3,750,000,000	II/9-II/20	Л.Энхбаяр Т.Жамбаажамц Н.Мөнхцэлмэг П.Наранцэцэг Ш.Түмэнбаяр
4	“Туул сонгино усны нөөц” ХК	2007.03.15	13,200,061,250	III/2-III/13	Л.Энхбаяр П.Наранцэцэг Б.Энхбат
5	“Хай би ойл” ХК	2007.04.19	1,000,000,000	III/4-III/12	Ж.Болормаа Ц.Орхонтамир Б.Энхбат
6	“Оллоо” ХК	2007.08.17	582,029,800	III/12-III/19	Г.Мөнгөнхуяг П.Наранцэцэг Н.Мөнхцэлмэг
7	“Гермес центр” ХК	2008.04.18	2,356,290,000	III/13-III/20	Г.Мөнгөнхуяг Ц.Орхонтамир С.Тулгаа
8	“Ремикон” ХК	2008.05.08	2,970,551,800	I/05-I/20	Т.Жамбаажамц С.Цэвэгмид
9	“Нако түлш” ХК	2007.11.29	363 000 000	III/30-IV/8	Л.Энхбаяр Ц.Цэрэнбадрал Ш.Түмэнбаяр П.Наранцэцэг
10	“Хөх ган” ХК	2008.06.12	3,039,527,200	IV/13-IV20	Л.Халиун Н.Мөнгөнчимэг Ц.Орхонтамир
11	“Туул сонгино усны нөөц” ХК	2007.03.15	13,200,061,250	XI/10-XI/17	С.Тулгаа Б.Энхбат П.Наранцэцэг

Хороо 2006-2008 оны шалгалтын дүнгээр цаашид ажиллах боломжгүй болсон гэж дүгнэгдсэн ХК-иудын асуудлыг дампууруулах, хэлбэрийг нь өөрчлөх, татан буулгах зэрэг аль тохирох арга замаар шийдвэрлэн хөрөнгийн биржийн бүртгэлээс хасч цэвэрлэх нь хөрөнгийн зах зээлийн цаашдын хөгжилд нааштай нөлөө үзүүлнэ, хөрөнгө оруулагчид цаанаа хөрөнгөөр баталгаажаагүй үнэт цаасыг худалдан авах явдал үгүй болно гэж үзээд 2008 оны 1 дүгээр улиралд 166 ХК-ийн арилжааг зогсоосон билээ.

2008 оны 3 дугаар сарын 28-ны өдөр Хороо “Арилжааг зогсоосон компанийн талаар авах зарим арга хэмжээний тухай” 77 дугаар тогтоол гаргасны дагуу эдгээр компанийн удирдлагад хувьцаа эзэмшигчдийнхээ хурлыг хуралдуулж, цаашид үйл ажиллагаагаа сэргээх эсэх, компаниа татан буулгах эсэх талаар гаргасан шийдвэрээ Хороонд ирүүлэх хугацаатай үүрэг өгч ажиллаж байна.

Арилжааг нь зогсоосон ХК-иудыг үйл ажиллагаа явуулж буй орон нутгаар хуваан үзвэл:

2009 оны 12 дугаар сарын байдлаар

Д/д	Үйл ажиллагаа явуулж буй аймаг, хот	Арилжааг нь зогсоосон ХК-ийн тоо	ХНХ-аар дээрх асуудлыг хэлэлцсэн ХК	Арилжаа сэргээх хүсэлт гаргасан ХК
1	Архангай	4	0	0
2	Баян-Өлгий	4	1	1
3	Баянхонгор	6	0	1
4	Булган	5	0	0
5	Говь-Алтай	-	-	-
6	Говь-Сүмбэр	2	0	0
7	Дархан	15	4	2
8	Дорнод	9	1	1
9	Дорноговь	3	0	0
10	Дундговь	4	2	2
11	Завхан	7	0	0
12	Орхон Уул	5	1	2
13	Өвөрхангай	12	0	0
14	Өмнөговь	1	1	1
15	Хөвсгөл	2	1	1
16	Ховд	4	0	0
17	Хэнтий	6	0	0
18	Сүхбаатар	1	0	0
19	Сэлэнгэ	14	0	0
20	Төв	22	3	0
21	Увс	9	1	1
22	Улаанбаатар	31	5	3
	Бүгд	166	20	14

Хорооны дээрх албан шаардлагын дагуу арилжааг нь зогсоосон 166 ХК-иас 34 ХК хувь нийлүүлэгчдийн хурлаараа арилжаагаа сэргээх эсхүл компанийн хэлбэрийг өөрчлөх асуудлаа авч хэлэлцэн, цаашид компанийн үйл ажиллагаагаа сэргээн, хуулиар хүлээсэн үүргээ хэрэгжүүлэн хэвийн ажиллах боломжтой хэмээн холбогдох журмын дагуу арилжаа сэргээх болон компанийн хэлбэрээ өөрчлөх хүсэлтээ Хороонд ирүүлээд байна. Үүнээс 20 компанийн хувьцааг үнэт цаасны бүртгэлээс хассан ба “Тэнгис”, “Монгол шинэс”, “Бааз”,

“Хархорин”, “Чацаргана”, “Дархан тээвэр” гэсэн 6 ХК-ийн хувьцааны арилжааг сэргээхээр Хороо шийдвэрлэсэн болно.

Үлдсэн ХК-иудын тухайд компанийн удирдлага нь тодорхой бус, өмч хөрөнгө нь үрэгдсэн, өмч хөрөнгө нь банкны зээлийн барьцаанд хураагдсан, шүүхийн шийдвэрээр татан буугдсан, томоохон хувьцаа эзэмшигчид идэвхи санаачилага муу, ХК-ийн талаарх хуулийн мэдлэг сул байгаа зэрэг шалтгааны улмаас хувь нийлүүлэгчдийн хурлаа зарлан хуралдуулж хариу ирүүлээгүй байна. Тухайлбал, “Авто-28”, “ХААБЗ”, “Дэл Баянбулаг”, “Жинст”, “Цагдуултай”, “Завхан тээх”, “Улбаа”, “Гантөмөрт”, “Модлог”, “Туул баян” зэрэг компанийн өмч хөрөнгө нь үрэгдсэн, “Ар Баянхангай”, “Агро-Амгалан”, “Өргөн жим”, “Монгол эд импекс” зэрэг компаниудын өмч хөрөнгө нь үрэгдсэн эсхүүл банкны зээлийн барьцаанд хураагдсан байгаа.

Үүний дагуу одоогийн байдлаар дээр дурдсанчлан өмч хөрөнгө нь үрэгдсэн эхний ээлжинд 55 компанийн тухайн үед удирдаж байсан удирдлагыг хууль хяналтын байгууллагад шилжүүлэхэд бэлэн болоод байна.

Энэ ажлын хүрээнд дараах ажлуудыг хийв. Үүнд:

- ТӨХ, НӨХГ зэрэг газруудын архиваас эдгээр компаниудын хувьчлагдах үеийн хөрөнгийн жагсаалтыг хуулбарлан авав.
- “ҮЦТТТХТ” ХХК-иас хувьцаа эзэмшигчдийн тоо, данс нээлгэсэн эсэх талаарх мэдээлэл, эрх бүхий этгээдийн шийдвэр болон зээлийн барьцаанд тусгаарласан эсэх судалгаа гаргуулан авав.
- ЭХЭБГ-аас дээрх компаниудын өмчлөлд байгаа үл хөдлөх хөрөнгүүдийн жагсаалтыг гаргуулан авав.
- ИБМТ-өөс эдгээр компаниудын хяналтын багцыг эзэмшигчдийн хаяг, холбоо барих утасны талаарх судалгаа гаргуулан авав.
- Бүх ХК-иудын талаар Цагдаагийн байгууллагад шилжүүлэхэд зориулан дэлгэрэнгүй танилцуулга бэлтгэв.

2009 онд нийт “Дээж”, “Монхөлөг”, “Төв оргил”, “Манзушир” “Саван трейд”, “Засгийн газрын мэдээ сонин”, “Дэлгэртрейд”, “Билгэх баянбүрд”, “Баруунурт Ус” зэрэг 9 ХК-ийн гаргасан үнэт цаасыг бүртгэлээс хассан байх бөгөөд “Харшийн гэгээ”, “28 дугаар бааз”, “Хотгор”, “Хайлааст”, “Цацрал Мон” зэрэг 5 ХК-ийн үнэт цаасыг бүртгэлээс хасах эсэх асуудал хянагдаж байна. 2009 оны эцсийн байдлаар нэр бүхий 14 ХК-ийн 10.019 жижиг хувьцаа эзэмшигчдэд ногдох 140.753.593 төгрөгийн ногдол хувийн мөнгийг үнэт цаасны хадгаламжийн байгууллагад байршуулаад байна.

Хорооны хуралдаанд Булган, Дархан-уул, Өвөрхангай аймгуудын анхан шатны шүүхийн шийдвэрээр 2004-2008 оны хооронд татан буугдаж, давж заалдах хугацаа нь өнгөрсөн “Зүрх уул”, “Жирмийн сүлжээ”, “Эд хэрэглэгчдийн төв”, “Шанх”, “Найд”, “Дархан худалдаа”, “Мон ургац”, “Магсаржав”, “Мөнхсансар” зэрэг 9 ХК-ийн гаргасан үнэт цаасыг бүртгэлээс хасах асуудлыг шийдвэрлүүлээ.

“Дархан хөвөн”, “Алтай нэгдэл” гэсэн 2 ХК-ийн хяналтын багцын хувьцааг эзэмшигчдээс ирүүлсэн бусад хувьцаа эзэмшигчдийн өмчлөлийн хувьцааг худалдаж авахаар гаргасан саналыг зохих хууль, журмын дагуу хянаж худалдаж авах доод үнийг тогтоон Хорооны хуралдаанд оруулж шийдвэрлүүлээ.

Хувьцаат компаниудад хийгдсэн үзлэгийн дүнгээс харахад дор дурьдсан нийтлэг зөрчил, хууль бус үйлдлүүд гарч байсан.

- Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 10 дугаар зүйл, Компанийн тухай хуулийн 60.3-д заасан үүргээ биелүүлдэггүй, үүний үр дагавраар компанийн ТУЗ, гүйцэтгэх захирлын бүрэн эрх дууссан зөрчил ихэнх компаниуд дээр илэрч байна. Хувь нийлүүлэгчдийн хуралыг “Хувьцаат компанийн хувь нийлүүлэгчдийн хурлын зар мэдээ хүргэх тухай” журмын дагуу хуралдуулдаггүй.

- Хороонд бүртгэлтэй үнэт цаасаа бүртгэлээс хасуулж зохион байгуулалтын хэлбэрээ өөрчилсөн шийдвэр гаргуулаагүй, хувь нийлүүлэгчиддээ ногдол хувь өгөлгүйгээр компанийн өмч хөрөнгийг үрэгдүүлэн хариуцах эзэн олдохгүй болсон байна; Жишээ нь “Дээж” ХК, Жаргалант үйлс ХК, Монгол шинэс ХК, “Алтай ханын материал” ХК, “Эвлэл” ХК, “Цагдуултай” ХК г. м.

- Санхүүгийн тайлангаа хуульд заасан хугацаанд нь Хороонд хүргүүлээгүй, санхүүгийн тайлангийн хураангуй үзүүлэлтүүдийг өдөр тутмын мэдээллийн хэрэгслүүдэд нийтлүүлэх замаар хувьцаа эзэмшигчдэдээ компанийн санхүүгийн байдлын талаар мэдээлэл хүргүүлээгүй хууль зөрчсөн; Ихэнх компаниуд дээр энэ зөрчил байна.

- Нилээд хувьцаат компанийн тухайд өмч хөрөнгийн маргаантай асуудал үүсч шүүх, хуулийн байгууллагад хандаад байгаа болон хандах шаардлагатай болсон нөхцөл байдал үүсээд байна;

- Хувийн хэвшил давамгайлсан хувьцаат компаниудын жижиг хувьцаа эзэмшигчдийн нэгж хувьцаанд ноогдох ашгийн түвшин, хяналтын багцыг эзэмшигчдийн нэг хувьцаанд оногдох ашгийн түвшингээс маш доогуур, ихэнх тохиолдолд огт ногдол ашиг авч чадахгүй байна.

Энэ нь доорхи үндсэн шалтгаануудаас үүдэлтэй гэж үзсэн байна. Үүнд;

- Санхүүгийн бүртгэл, тайланг зориудаар дарагдуулан гаргаж санхүүгийн 2 бүртгэл хөтөлдөг байх магадлалтай;

- Компаниудын үйл ажиллагааны орлого болон үндсэн хөрөнгийн борлуулалтын орлого нь зөвхөн тухайн компанийг удирдаж байгаа том хувьцаа эзэмшигчид болох цөөхөн хэдэн тооны хүмүүсийн амьдралыг тэтгэгч эх үүсвэр болж байна;

- Анх хувьчлагдах үеийн болон одоо тендер саналаар худалдагдаж байгаа хувьцааны үнэ бодитой биш байна. Гэтэл бодит байдал дээр хувьцаагаар эзэмших эрх нь гэрчлэгдэж буй эд хөрөнгө асар их үнэтэй байна.

- Хяналтын багцын хувьцааны ханш Хөрөнгийн биржээр арилжаалагдаж байгаа жижиг хувьцааны ханш эрс өөр байгаа зэрэг болно.

Үзлэгийн ажлын хэсгүүдийн ажилласан байдлаас үндэслэн цаашид Үнэт цаасны газар дараах асуудалд цаашид анхаарал ажиллахаар төлөвлөж байна. Үүнд:

ТУЗ-ын болон гүйцэтгэх захирлын бүрэн эрх дуусгавар болж хууль бус үйл ажиллагаа явуулж буй ХК-иудын нэрсийг өдөр тутмын хэвлэлд нийтэлж шаардлагатай гэж үзвэл дансыг хаах, тэдгээр компаниудын хувьцаа эзэмшигчдэд мэдэгдэх, үйл ажиллагааг нь

зогсоох, хуулийн байгууллагад шилжүүлж шийдвэрлүүлэх зэрэг шат дараалсан арга хэмжээ авах;

Хорооноос хувьцаат компаниуд, үнэт цаас (хувьцаа), шинээр гарсан дүрэм журмын талаар иргэдийн заавал мэдэж байх асуудлуудыг цогцоор нь хамруулсан хялбаршуулсан лавлагаа материалыг зориуд боловсруулан нэгтгэн хэвлүүлж, орон нутагт хүртээмжтэй тоогоор хүргэх шаардлага гарч байна;

Зохион байгуулалтын хэлбэрээ хуулийн дагуу өөрчлөөгүй, хувьцаа эзэмшигчиддээ ногдол хувь өгөөгүй, олон хувь нийлүүлэгчдийн өмчийг дур мэдэн өөрсдийн дураар зарцуулсан асуудлыг компани тус бүрээр нарийвчлан судалгаа гаргасны үндсэн дээр хувьчлагдах үеэс нь эхлэн хөрөнгийн шилжилт хөдөлгөөнийг холбогдох эрх бүхий газруудтай хамтран тогтоож, хөндлөнгийн үнэлгээний газраар бодит үнэ цэнийг нь тогтоолгон буруутай этгээдээр нь тухайн компанийн хувьцаа эзэмшигч олон иргэдийг хохиролгүй болгох нэгдсэн арга хэмжээг холбогдох хууль журмын дагуу авах;

Орон нутгийн иргэдийн зүгээс ихээхэн ашиг орлоготой ажилладаг ХК-иуд ногдол ашиг хуваарилахгүй хувьцаа эзэмшигчдийг хохироож, олон хүний хувь нийлүүлсэн хөрөнгөөр бий болсон ашгийг зөвхөн багцыг нь авсан хэдхэн хүн өөрсдийнхөө эрх ашигт нийцүүлэн завшиж байгаа нь зүйд нийцэхгүй байгааг анхаарч ашгийнхаа тодорхой хувийг хувьцаа эзэмшигчдэдээ жил бүр заавал хуваарилж байх заалт хуульд оруулж өгөхөөс гадна дээрх дотоод мэдээлэлд үндэслэн өмчлөгчдийн эрх ашгийг хохироож буй этгээдэд олон улсын жишгийн дагуу эрүүгийн хариуцлага хүлээлгэдэг хууль эрх зүйн болон зохион байгуулалтын арга хэмжээ авах

СЗХ-ны орон нутгийн төлөөлөгчдөд Хорооноос гарын авлага болох материалууд, Хорооны үйл ажиллагаатай холбогдсон мэдээллүүдийг тухай бүр хүргэж байх шаардлагатай байна. Интернэтээс манай вэб-сайтад буй материалыг бүрэн ашиглаж байх;

ХК-ийн өмч хөрөнгөтэй холбогдсон цэгцэлбэл зохих асуудлууд орон нутагт байна. Тухайлбал: өөрийн эзэмшиж буй хувьцаандаа тохирсон хөрөнгөө тооцож байна гэсэн үндэслэлээр компанийн тодорхой хөрөнгийг өөрийн нэр дээр гэрчилгээ авсан, түүнийгээ бусдад зарсан, барьцаалсан байх жишээтэй байна. Энэ зөрчлийг арилгаж цаашид давтан гаргуулахгүй байхын тулд Үл хөдлөх хөрөнгийн бүртгэлийн газарт Хорооноос асуудал болгон тавьж ХК-ийн хөрөнгөтэй холбоотой асуудлаар Хорооны шийдвэргүйгээр гэрчилгээ олгохгүй байх асуудлыг орон нутагт журамлах шаардлагатай байна;

Хороо, Хөрөнгийн биржид бүртгэлтэй ХК-иудыг үйл ажиллагаа, үндсэн үзүүлэлтүүдээр нь яаралтай зэрэглэл тогтоож, Хөрөнгийн биржийн бүртгэлийн шалгуур үзүүлэлтүүдийг шинэчлэх. Ингэснээр нэг хэсгийг нь бүртгэж, татан буулгах, дампууруулах хэсгийг ялган хууль хяналтын байгууллагатай хамтран шийдвэрлүүлэн цэгцлэх ажлыг зохион байгуулах

ХОЭБ-ийн үлдэгдлээр хувьцаа худалдаж авсан хувьцаа эзэмшигчдийг тогтоох, тэдгээрт мэдээлэл өгөх ажлыг Иргэний бүртгэл, мэдээллийн төв, МХБ ХК, ҮЦТТТХТ болон харьяалах брокер дилерийн компаниудтай хамтран компани ажил болгон зохион байгуулж, холбогдох компанид нь хаягийг нь тогтоож өгөх замаар тендер санал зарлах ажлыг үр дүнтэй хэлбэрээр зохион байгуулж данс нээгээгүй хийгээд хувьцаа эзэмшиж байгаа эсэхээ мэдэхгүй байгаа иргэдийн асуудлыг нэг мөр шийдвэрлэх;

Хувьцаа эзэмшигч, хөрөнгө оруулагчийн эрх ашгийг хамгаалах талаар: Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуульд хөрөнгө оруулагч, үйлчлүүлэгчдийн эрх ашгийг хамгаалах асуудлыг СЗХ-ны нэг үндсэн чиг үүрэг гэж заасан байдаг бөгөөд үйлчлүүлэгчдэд хөнгөн шуурхай үйлчилж, тавьсан хүсэлт, гомдлыг нь хуулийн хүрээнд бүрэн барагдуулах, улмаар санхүүгийн зах зээлд итгэх итгэлийг нь бий болгох зорилт тавин ажиллаж байна.

Ингээд нэн тэргүүнд хувьцаа эзэмшигч нарын ногдол ашгийн болон хувьцаа худалдсаны мөнгийг арилжааны банкуудад байршуулж байгаад эрсдэлд оруулсан хохирлыг барагдуулах зорилгоор үлдэгдэл 560 сая төгрөгийг иргэдэд олгохоор Монгол Улсын Засгийн Газрын 2006 оны 7 дугаар сарын 05-ны 155 дугаар тогтоолоор шийдвэрлэсний дагуу “ҮЦТТТХТ” ХХК-тай хамтран тараах ажлыг зохион байгуулж дуусгалаа.

Компанийн удирдлага, эрх бүхий албан тушаалтан болон томоохон хувьцаа эзэмшигч, брокер, дилерүүдийн зүгээс хувьцаа эзэмшигч, хөрөнгө оруулагчдын үнэт цаасаар гэрчлэгдсэн өмчлөх эрхийг зөрчих, түүнд хохирол учруулах үйлдэл нилээд байсан. Энэхүү үйлдлүүд нь тэдний санал өгөх, ногдол ашиг хүртэх эрхийг хязгаарлах, татан буулгах үед компанийн хөрөнгөөс эзэмшиж буй хувьцаандаа ногдох ногдол хувь авах, хувьцааг нь хувьцаа эзэмшигч болох өмчлөгчийн зөвшөөрөлгүй худалдах, бусдад шилжүүлэх, компанийн хөрөнгийг үнэгүйдүүлэх, хуульд заасан журам зөрчиж бусдад худалдах, шилжүүлэх, зээлийн барьцаанд тавих гэх мэтээр илэрч байна.

Мөн бүртгэлтэй ХК-ийн дийлэнх олонх нь хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаа хийдэггүй, хувьцаа эзэмшигчдийг мэдээллээр хангадаггүй, хяналтын багц эзэмшигчид нь бусдынхаа хувьцааг худалдан авахаар санал гаргах талаар хуулиар хүлээсэн үүргээ биелүүлэхгүй байгаагийн зэрэгцээ компанийн хөрөнгийг дур мэдэн өөрийн эрх ашигт нийцүүлэн зарцуулах, ашигтай ажилласан ч ногдол ашиг хуваарилахгүй байх зэргээр олон тооны жижиг хувьцаа эзэмшигчдийн эрх ашгийг хохироох явдал түгээмэл байна.

Сүүлийн жилүүдэд хувьцаа эзэмшигчдийн дансан дахь хувьцааг зөвшөөрөлгүйгээр зарж борлуулан, арилжаалдаг байсан зохисгүй үзэгдэл хумигдаж, мэргэжлийн оролцогчид маань ёс зүй, нэр төрийн үнэт зүйлсээ эрхэмлэх хандлагатай болж байна.

Хорооны Үнэт цаасны газрын Улсын байцаагчид 2009 онд хойш тус Хороонд хувьцаа эзэмшигч, аж ахуйн нэгж байгууллагаас ирүүлсэн өргөдөл гомдолтой холбоотой асуудлаар улсын байцаагчийн нийт 134 албан шаардлагыг холбогдох байгууллага, албан тушаалтанд хүргүүлсэн ба зөвхөн “Таван толгой” ХК-ийн хувьд хувьцаа эзэмшигчдэд нь учирсан нэг тэрбум гаруй төгрөгийн хохирлыг барагдуулаад байна. Мөн хуулиар хүлээсэн үүргээ биелүүлээгүй, тавьсан шаардлагыг хэрэгжүүлээгүй албан тушаалтан болон аж ахуйн нэгжид нийт 2.830.000 төгрөгийн захиргааны шийтгэл ногдуулсан байна.

Ер нь хувьцаа эзэмшигчдийн хувьцааг тэдний зөвшөөрөлгүй биржийн арилжаагаар худалдаж, завшсан үйлдүүд ихээр гарч байсан бөгөөд энэхүү зөрчлөөс үүдсэн гомдол, өргөдлийг хүлээн авч Иргэний хууль, Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулиар олгогдсон бүрэн эрхийн хүрээнд, шүүхийн бус журмаар урьдчилан шийдвэрлэж ирсэн.

Ийнхүү шийдвэрлэсэн Хорооны тогтоол буюу захиргааны актуудыг хуульд нийцсэн эсэх талаар 2009 онд Захиргааны хэргийн шүүх 2 хэргийг, Иргэний хэргийн шүүх 5 хэргийг

тус тус үүсгэн шалгасан бөгөөд дээрх хэргүүдийн 2009 онд болсон нийт 6 шүүх хуралдааны дүнгээр Хорооны шийдвэрүүдийг хүчин төгөлдөр хэвээр баталсан байна.

Бүх нийтийн санхүүгийн боловсролыг дээшлүүлэх талаар: 1990-ээд оны эхэнд хөрөнгө оруулалтын эрхийн бичгээр хувьцааны эзэн болсон олон мянган иргэн эзэмшиж буй хөрөнгийнхөө мөн чанарыг мэдэхгүй буюу дутуу ойлгосноосоо болоод Үнэт цаасны төлбөр тооцоо, төвлөрсөн хадгаламжийн төвд харилцах дансаа ч нээлгээгүй, нээлгэсэн ч хяналт тавих арга механизмаа бүрэн мэдэхгүй байгааг яах аргагүй санхүүгийн дулимаг боловсролтой холбож үзэхээс өөр аргагүй юм.

Үнэт цаасны газар үнэт цаасны зах зээлийн онцлог, цаашдын хандлага, арга хэрэгслүүдийн талаар ойлголт өгөх гарын авлага, материал хэвлэн иргэдэд тараах, тодорхой арга хэмжээнүүдийг зохион байгуулах зэрэг ажлуудыг хийлээ. Тухайлбал,

- АХБ-тай хамтран Үнэт цаасны зээлийг зохицуулах хууль тогтоомжийн бүрэн эмхэтгэл, хөрөнгийн зах зээлийн тухай гарын авлага, ханын зурагт хуудас зэргийг хэвлүүлж ажилдаа ашиглаж байна.
- 2009 онд АХБ-тай хамтран нийтийг хамарсан “Иргэдийн санхүүгийн боловсролд” өдөрлөгийг Орхон, Хөвсгөл аймгийн төвүүдэд тусгай хөтөлбөрөөр зохион байгууллаа. Уг өдөрлөгийн үеэр 416 хүнд зөвлөгөө өгч, танилцуулга, лавлагаа, зөвлөмжийн эмхэтгэлийг тараан сурталчилсан ба 2.9 сая төгрөгийн мөнгөн хөрөнгийг эздэд нь тараалаа.
- 2009 онд Үнэт цаасны газрын удирдлагуудаас “Би ТВ”-ээр Хорооноос хөдөө орон нутагт ажилласан байдлын талаар ярилцлага, “ТВ 8” телевизээр шууд ярилцлагад оролцож, хөрөнгийн зах зээлийн цаг үеийн тулгамдсан асуудлын талаар мэдээлэл хийж, үзэгчдийн сонирхсон асуултад хариулсны дээр “Өнөөдөр”, “Зууны мэдээ” ”Зууны шуудан” зэрэг сонинд 4 удаа ярилцлага өгч, Хорооноос авч хэрэгжүүлж байгаа бодлого, арга хэмжээний талаар сурталчлав. Хөрөнгийн зах зээлийн талаарх мэдээ, мэдээлэл, Хорооноос авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээнүүдийн талаар радио, телевиз, сонин хэвлэлээр өргөн сурталчилж ажиллав.
- Үнэт цаасны зах зээл дээр ажиллагсдад зориулсан семинар, уулзалт-ярилцлагыг мэргэжлийн оролцогчийн ёс зүйн асуудал, нийтэд санал болгон үнэт цаас гаргагчид тавих шаардлага, компанийн засаглалын зарчим, Хөрөнгө оруулалтын сангийн тухай хуулийн төслийн хэлэлцүүлэг зэрэг асуудлаар зохион байгууллаа.
- Шихихутаг дээд сургуультай хамтран хуулийн сургуулийн оюутнуудын дунд “Бизнесийн эрх зүй- 2009” сэдэвт эрдэм шинжилгээний хурал зохион байгууллаа.
- КТМС-ийн ахлах курсын оюутнуудын дунд зохион байгуулагдсан “Үнэт цаасны зах зээл” сэдэвт уралдаанд онол арга зүйн болон сургалтын материал, гарын авлага, материалын туслалцаа үзүүлж хамтран ажилласан.

Үнэт цаасны зах зээл дээр ажиллахыг хүсэгчдэд анхан шатны мэдлэг олгох сургалтыг Хөрөнгийн биржийн сургалтын төвөөр дамжуулан, мэргэжлийн эрх олгох сургалтыг СЗХ-ны сургалтын хөтөлбөрийн дагуу зохион байгуулсан. Сургалтын агуулга, чанарт онцгой

анхаарч, шинэчлэн сайжруулсан бөгөөд 2 хоног байсан үргэлжлэх хугацааг нь 14 хоног болгон сунгаж суралцагчдад илүү гүнзгий, илүү өргөн мэдлэг олгох нөхцлийг бүрдүүлсэн юм.

Дээрх сургалтыг 2009 оны 4 дүгээр сарын 20-ны өдрөөс 27-ны өдрийг хүртэл 7 хоног явуулж, 32 хүнийг хамруулж, эрх олгох шалгалтыг уг 32 хүн болон өмнө шалгалтад тэнцээгүй 8 хүн нийт 40 хүнээс авсанаас 34 хүнд эрх олгосон байна.

Мөн өмнө эрх авсан энэ салбарт ажиллаж буй боловсон хүчнүүдийг аттестатчлах сургалтыг мөн 2009 оны 12 дугаар сарын 07-ны өдрөөс мөн сарын 14-ний өдрүүдэд зохион байгуулж уг сургалтад 74 хүн хамрагдсан байна.

Эдгээр сургалтын дүнд Хороонд 19.1 сая төгрөгийн орлого орсон байна.

Газрын ажилтнуудын мэргэжил ур, чадварыг дээшлүүлэх талаар зохион байгуулсан сургалт семинар

Дээр дурьдсан семинаруудад газрын ажилтнуудыг хамруулсны зэрэгцээ дараах сургалт семинарт газрын ажилтнууд оролцож, мэдлэг чадвараа дээшлүүллээ:

1. Монгол болон Япон улсуудын хооронд Чөлөөт худалдааны гэрээ, хэлэлцээр байгуулах бэлтгэл ажлын хүрээнд зохион байгуулагдсан сургалт

2. Хорооноос 2009 оны 6 дугаар сарын 26-нд зохион байгуулсан “Архив бичгийн хэргийн хөтлөлт” сэдэвт сургалтад газрын бүх ажилтууд хамрагдсан.

3. Азийн хөгжлийн банкнаас Хороонд ажиллаж буй мэргэжилтний зохион байгуулсан “Хөрөнгө оруулалтын сангийн тухай”, “Дотоод мэдээлэл”, “Итгэлцлийн тухай” гэсэн сэдэвт сургалт

4. БНХАУ-ын Бээжин хотод зохион байгуулагдсан “Дэлхийн санхүүгийн хямрал ба хөрөнгийн удирдлага” сэдэвт зөвөлгөөнд 2 ажилтан

5. Японы JSDA-аас зохион байгуулсан семинарт 1 ажилтан

6. БНСУ-ын Сөүл хотод зохион байгуулагдсан “БНСУ-ын Хөрөнгийн зах зээлийн өнөөгийн байдал” семинарт 2 ажилтан

6. USAID ба IFC ээс зохион байгуулсан “Компанийн засаглалын үндэсний сургагч бэлтгэх” сэдэвт сургалтанд 2 ажилтан оролцсон

7. “Хөрөнгийн үнэлгээний эрх олгох сургалтад 3 ажилтан хамрагдсан.

8. “Евроази” ХХК-иас зохион байгуулсан “Хадгаламжийн сертификат”-ын талаарх сургалтанд 3 ажилтан

9. Дэлхийн банкнаас зохион байгуулсан Санхүүгийн хямрал дах Азийн бондын зах зээл сэдэвт сургалтад 1 ажилтан

10. Канадын орон сууцны даатгалын корпорацийн зөвлөхийн “Орон сууны зээлийн даатгал” сэдэвт сургалтад 1 ажилтан тус тус оролцсон байна.

Дэд бүтэц, зах зээлийн зохицуулалт

1. Ипотекоор /үл хөдлөх хөрөнгийн барьцаагаар/ баталгаажсан үнэт цаас гарган дотоод, гадаадын хөрөнгийн зах зээл дээр борлуулах замаар ипотекийн анхдагч болон хоёрдогч зах зээлийг хөгжүүлж, Монгол улсын хүн амыг орон сууцаар хангах, цаашид орчин үеийн хот байгуулалтыг эрчимжүүлэхэд чиглэсэн урт хугацаат санхүүжилтийн тогтолцоог бий болгож төгөлдөржүүлэх шаардлага нийгэмд тодорхой хэмжээгээр байгаа юм.

2009 онд “Монголын ипотекийн корпораци” ХХК-ийн Хороонд хандан гаргасан зээлийн хөрөнгөөр баталгаажуулан үнэт цаас гаргаж, шинэ хямд эх үүсвэр татах замаар ипотекийн анхдагч зах зээлийг хөрөнгийн зах зээлтэй холбох, улмаар зээлийн хүүг бууруулж хүн амын орон сууцны хэрэгцээг хангах төрийн бодлогыг хэрэгжүүлэхэд дэмжлэг

үзүүлэх зорилготойгоор нийтэд санал болгон гаргах 2,5 жилийн хугацаатай, жилийн 14 хувийн хүүтэй, 3,5 жилийн хугацаатай, жилийн 14,3 хувийн хүүтэй, 5 жилийн хугацаатай, жилийн 14,5 хувийн хүүтэй нэг бүр нь 1 000 000 /нэг сая/ төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий нийт 25 000 /хорин таван мянга/ ширхэг “МИК” бондыг үнэт цаасны бүртгэлд бүртгэх асуудлыг хянаж шийдвэрлүүллээ. Одоогийн байдлаар Худалдаа хөгжлийн банк, Капитрон банкууд 3 төрлийн нийт 5700 ширхэг бондыг тэнцүү хэмжээний зээлийн багцаар сольж аваад байна.

Хөрөнгийн зах зээлийн тогтвортой байдлыг хангах, хөрөнгө оруулагчдын эрх ашгийг хамгаалах чиг үүргээ хэрэгжүүлэх үүднээс Анод банкинд үнэт цаасаа нийтэд санал болгон гаргах зөвшөөрлийг олгох саналыг Хорооны хуралдаанд оруулсаны хувьд үний дотор хөрөнгийн зах зээлийн тогтвортой байдлыг эрхэмлэн “Анод банк” ХК-ийн хувьд цаашид авах арга хэмжээний талаар өөрийн байр суурь болон саналаа илэрхийлж ажилласан.

Ийнхүү бүрэн эрхт төлөөлөгч томилогдсоноос хойш Анод банкинд цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаарх санал боловсруулах, ялангуяа уг банкинд өөрчлөн байгуулах, бүтцийн өөрчлөлт хийх санал боловсруулах үүрэг бүхий Монголбанк, Сангийн яам, Санхүүгийн зохицуулах хорооны хамтарсан ажлын хэсэгт Газрын дарга орж ажилласан байна.

Энэ ажлын хэсэгт орсон төлөөллөөрөө дамжуулан жижиг хувьцаа эзэмшигчид болох олон мянган иргэдийн эрх ашгийг хамгаалах, оруулсан хөрөнгө оруулалтын эрсдэлийг аль болох багасгах талаар Анод банкинд цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаарх саналын хэд хэдэн хувилбарыг дэвшүүлсэн бөгөөд бүх саналыг ажлын хэсгийн гишүүд нарийвчлан судалж, дутагдалтай болон давуу талыг нь хэлэлцсэний дүнд Хороо болон Сангийн яам, Монгол банкны санамж бичигт гарын үсэг зураад байна.

Энэ ажлын дүнд Анод банкны Хөрөнгийн бирж дээрх хувьцааны арилжааны хаалтын ханшаар бодож нэгж хувьцааг эргүүлэн худалдаж авахаар зарчмын хувьд тохиролцоонд хүрээд байна.

2. Тайлант хугацаанд зах зээл дээр үйл ажиллагаа явуулж байсан “Финанс линк групп”, “Масдак”, “Тулгатчандмань баян”, “Гендекс” брокер, дилерийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг шинэчлэн, “Евроазиа капитал монголиа” ХХК-иудад андеррайтерийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл, “Эм Даблю Ти Эс”, “ДиСиЭф”, “Тэнгри секюритиес” гэсэн ХХК-д брокер, дилерийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл тус тус олгосон.

Үнэт цаасны зах зээлд үйл ажиллагаа явуулж байсан компаниудын тусгай зөвшөөрлийг нөхцөл шаардлагыг хэрхэн хангаж ажиллаж байгаа байдал, үйл ажиллагаа явуулж байсан байдал, харилцагчдаас нь гомдол гарсан эсэх, түүнийг хэрхэн барагдуулсан зэргийг харгалзан, сайтар нягтлан шалгасан бөгөөд үүнтэй холбогдон “ДиСиЭф” ХХК-ийн андеррайтерийн үйл ажиллагаа эрхлэх, “Скайскрапер” ХХК-ийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг тус тус хүчингүй болгож, “Бумбат Алтай”, “Алтан хоромсог”, “Эрдэнэст” ХХК-ийн тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлэх арга хэмжээ авч, “Өндөрхаан инвест” компаниудын тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлснийг сэргээх арга хэмжээг авч ажиллаа.

Мөнтүүнчлэн “Нортенсек”, “Батс инвест”, “Ворлдкей”, “Зюс капитал” зэрэг ХХК-иудын хувь нийлүүлэгчдийн бүтэц, хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээнд өөрчлөлт оруулах асуудлуудыг зохих журмын дагуу хянаж шийдвэрлэлээ.

Тусгай зөвшөөрөл нь хүчингүй болсон брокер, дилерийн компаниудын харилцагчдыг шилжүүлэх тухай журмын дагуу Архангай, Завхан, Хөвсгөл, Өмнөговь аймгийн хувьцаа эзэмшигчдэд үйлчлэх компанийг уралдаант шалгаруулалтын үндсэн дээр сонгон шалгаруулах комиссыг байгуулан ажиллуулж, Өмнөговь аймгийн харилцагчдыг “СиСиПи” ХХК-д, Архангай аймгийн харилцагчдыг “Алтан сан” ХХК-д, Хөвсгөл аймгийн харилцагчдыг “Гүүдсек” ХХК-д тус тус шилжүүлэх ажлыг зохион байгууллаа.

2009 онд системийн хэмжээнд 1.251,6 сая төгрөгийн орлого олж, 3.137,2 сая төгрөгийн зардал гарган 1.907,9 сая төгрөгийн алдагдалтай ажилласан байна. Нийт орлогын 76.2 хувийг нэр бүхий 4 компани бүрдүүлсэн байх бөгөөд 2008 оны дунд үеэс үнэт цаасны арилжааны идэвх суларч, борлуулалтын хэмжээ багассантай холбоотойгоор БДК-иуд арилжааны шимтгэлийнхээ хувь хэмжээг багасгасан явдал үндсэн орлогын хэмжээ буурахад нөлөөлсөн бол шинээр байгуулагдсан мэргэжлийн байгууллагуудын үйл ажиллагааны зардал системийн нийт зардлын хэмжээг өсөхөд нөлөөлжээ.


Нийт системийн капиталын 61.97 хувь хувийн компаниудад оногдож байгаа бол “Монголын хөрөнгийн бирж”, “Үнэт цаасны төлбөр тооцоо, төвлөрсөн хадгаламжийн төв” гэсэн төрийн өмчит 2 компани үлдсэн 38.03 хувийг буюу 8.5 тэрбум төгрөгийн активыг эзэмшиж байна

Системийн санхүүгийн нэгтгэлийг хавсралтаар үзүүлэв.

Үнэт цаасны бүртгэлд 2009 оны төгсгөлд 368 ХК-ийн 3.104.783.035 ширхэг хувьцаа хадгалагдаж байгаагаас төрийн болон орон нутгийн өмчит 51 ХК-ийн 1.859.571.249 ширхэг хувьцаа бүртгэлтэй байна. Мөн 5 төрлийн 887.272 ширхэг компанийн бонд хадгалагдаж байна.

2009 он гарсаар 3 дугаар улирлын байдлаар “Монголын хөрөнгийн бирж” ХК-иар нийт 190 удаагийн арилжаа явагдаж, 9251 хэлцлээр 49.895,3 мянган үнэт цаас арилжигдсаны 14.181,6 сая төгрөгийн төлбөр тооцоог гүйцэтгэсэн байна.

Арилжаалагдсан үнэт цаасны хэмжээ болон төрлийн бүтцийг графикаар харуулбал дараах байдалтай байна.



Өмнөх оны эцэст 515.872 сая төгрөгөөр үнэлэгдэж байсан үнэт цаасны зах зээлийн үнэлгээ 2009 оны сүүл үед 599.263 сая төгрөгт хүрч, 83.391 сая төгрөгөөр буюу 16.16 хувиар өссөн байна.



Үнэт цаасны зах зээлийн эерэг, сөрөг талуудыг харуулдаг гол үзүүлэлт болох ТОП-20 индексийн дундаж үзүүлэлт 2009 оны эхэнд 5511.01 нэгж байсан бол оны эцсээр 5917.34 нэгж болсон нь хувьцааны арилжааны идэвхи бага зэрэг нэмэгдэж, тухайн индексэд багтдаг хувьцаат компаниудын хувьцааны ханш өссөнөөс шалтгаалсан байна.

ТОП-20 индекс өмнөх оноос 2009.12.15–ны байдлаар 406.33 нэгж буурсан ба тайлант хугацаанд дээд үзүүлэлт 7833.69 нэгж байсан байна.



ХК-иудын хуулиар хүлээсэн үүргийн хэрэгжилтийг хангахад чиглэсэн зайны хяналтын талаар

2009 оны эхэнд бүртгэлтэй байсан нийт 376 ХК-иас ээлжит хурлын тухай мэдэгдэл, хурлын материалыг Хороонд ирүүлээгүй 190 ХК-ийн нэрсийг хувьцаа эзэмшигчид, харилцагч байгууллагуудад нь зориулсан удирдлагын нь бүрэн эрх дуусгавар болсон талаарх мэдээллийг “Өдрийн сонин”-ын 2009 оны 8 дугаар сарын 12-ны дугаарт хэвлүүлсэн.

Үнэт цаасны зах зээлийн мэргэжлийн оролцогч байгууллагуудад зайны хяналт тавьсан талаар болон ХК-иудын 2008 оны жилийн тайлан, 2009 оны хагас жилийн санхүүгийн тайланг болон мэргэжлийн оролцогч байгууллагуудын 2008 оны жилийн тайлан, 2009 оны бүх улирлуудын санхүүгийн тайланг шалган хүлээн авч нэгтгэн, танилцуулга бэлдэж, Хорооны удирдлагад танилцууллаа. Санхүүгийн тайланд үндэслэн зах зээлийн оролцогчдын үйл ажиллагааны үндсэн үзүүлэлтэд дүн шинжилгээ хийж байна.

Энэ ажиллагаанд нийт 164 ХК, 45 мэргэжлийн байгууллагын санхүүгийн тайлан нэгтгэгдэж, 45 мэргэжлийн байгууллагад тайлангийн хариу явуулаад байна.

2009 онд 26 ХК нийт 14.296.727.643 төгрөгийн ногдол ашиг тараасан. /судалгааг хавсаргав/

“Үнэт цаасны зах зээлийн мэдээллийн нэгдсэн сангийн журам” боловсруулан, Хороогоор батлуулсан бөгөөд уг журмын дагуу сан бүрдүүлэх ажлыг үргэлжүүлэн гүйцэтгэж байна.

Өнөөгийн байдлаар бүртгэлтэй ХК-ийн болон мэргэжлийн оролцогчдын хувийн хэрэг, санхүүгийн тайлангууд болон нэгтгэл, 5% болон хяналтын багц эзэмшигч, нэгдмэл сонирхолтой этгээдийн тухай мэдээлэл, газар дээрх үзлэг шалгалтын тайлан зэрэг мэдээллийн сан бүрдээд байна.

